



ЦАГ УУР, ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ
ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2025 оны 04 сарын 09 өдөр

Дугаар А/148

Улаанбаатар хот

Спорт заал ашиглах журам батлах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсгийг үндэслэн ТУШААХ нь:

1. Цаг уур, орчны шинжилгээний газрын "Спорт заал ашиглах журам"-ыг хавсралтаар баталсугай.

2. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа, хүний нөөцийн хэлтсийн дарга (Р.Бадмаадорж)-д үүрэг болгосугай.

ДАРГА



Э.БАТТУЛГА



ЦАГ УУР, ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ГАЗРЫН СПОРТ ЗААЛ АШИГЛАХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү журмын зорилго нь Цаг уур, орчны шинжилгээний газар /цаашид “байгууллага” гэх/-ын спорт заал ашиглахтай холбоотой харилцааг зохицуулахад оршино.

1.2. Албан хаагчид /цаашид “ашиглагч” гэх/-ын эрүүл мэндийг хамгаалах, өвчлөлөөс урьдчилан сэргийлэхэд чиглэсэн олон талт үйл ажиллагаа, биеийн тамир, спортын дасгал сургуулилт, уралдаан, тэмцээн, нэгдсэн арга хэмжээ зохион байгуулах зэрэгт спорт заалыг ашиглана.

Хоёр. Спорт заал ашиглалт, цэвэрлэгээ

2.1. Спорт заалыг ажлын өдрүүдэд 7.30-8.30, 12.30-13.30, 17.30-21.30 цагийн хооронд ашиглана.

2.2. Байгууллагын өмч ашиглалт хариуцсан мэргэжилтэн спорт заалны техник, тоног төхөөрөмж, хэрэгслийг бүртгэлжүүлэн бүрэн бүтэн байдал хяналт тавина.

2.3. Спорт заалны эрүүл ахуйг хангах үүднээс цэвэрлэгээ, агааржуулалт, ариутгалыг байгууллагын үйлчлэгч тогтмол хийнэ.

2.4. Спорт заалны түлхүүрийг Урьдчилан мэдээлэх хэлтэст хадгалах ба ашиглагч нь түлхүүрийг хүлээн авсан, хүлээлгэн өгсөн тухай бүртгэлийг дэвтэрт бичиж үлдээнэ.

2.5. Байгууллагын жижүүр өдөр бүрийн 22:00 цагт спорт заалны цонх, төхөөрөмж, гэрэл, цахилгаан, хувцас солих өрөө, ариун цэврийн өрөө, шүршүүрийн өрөөний хэвийн байдлыг шалгана.

Гурав. Спорт заал ашиглагчийн үүрэг

3.1. Тоног төхөөрөмжийг ашиглахын өмнө аюулгүй, хэвийн ажиллаж буй эсэхийг нягтлах үүрэгтэй бөгөөд спорт зааланд гэмтсэн, бэртсэн тохиолдолд байгууллага хариуцлага хүлээхгүй.

3.2. Ашиглагч спорт заал ашиглахдаа тоног төхөөрөмж, хэрэгсэл, эд хөрөнгөд хохирол учруулсан бол нөхөн төлөх үүрэгтэй.

3.3. Ашиглагч нь спорт заал болон угаалгын өрөө, шүршүүрийг цэвэр, эмх цэгцтэй, дараагийн үйлчлүүлэгч ашиглахуйцаар үлдээх үүрэгтэй.

3.4. Ашиглагч нь өөрийн эд зүйлсийн бүрэн бүтэн байдлыг хариуцах үүрэгтэй ба алдагдсан, эвдэрч гэмтсэн тохиолдолд байгууллага, ажилтан хариуцахгүй.

Дөрөв. Хориглох зүйлс

4.1. Спорт зааланд согтууруулах ундаа, мансууруулах төрлийн бодис хэрэглэх, хэрэглэсэн үедээ орохыг хориглоно.

4.2. Спорт зааланд гаднын хувцастай орох, хувцас солих өрөөнд эд зүйлээ ил задгай үлдээхийг хориглоно.

4.3. Спорт зааланд тэсэрч, дэлбэрэх болон галын аюултай бодис, галын аюулгүй байдал хангаагүй гэрэл, техник хэрэгсэл оруулах, ашиглах, зөвшөөрөлгүйгээр заалны техник, тоног төхөөрөмж, эд хөрөнгийг гадагш гаргахыг хориглоно.

Тав.Бусад

5.1. Спорт заалыг хамтын ажиллагаат бусад байгууллагад байгууллагын удирдлагын зөвшөөрлөөр ашиглуулж болно.

5.2. Журмын хэрэгжилтэд Захиргаа, хүний нөөцийн хэлтэс хяналт тавина.

5.3. Энэхүү журмыг зөрчсөн ашиглагчид хууль тогтоомж, дотоод журмын дагуу хариуцлага хүлээлгэнэ.

----oOo----

СПОРТ ЗААЛ АШИГЛАГЧИЙН БҮРТГЭЛИЙН ХУУДАС

№	Ашиглагчийн нэр	Огноо	Түлхүүр хүлээн авсан, хүлээлгэн өгсөн цаг	
1.				
2.				
3.				
4.				
5.				
6.				
7.				
8.				
9.				
10.				
11.				
12.				
13.				
14.				
15.				
16.				
17.				
18.				

----oOo----